



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ



ХУРАЛ 2017.04.28-НИЙ 15:00 ЦАГТ  
“БИДИСЕК ҮЦК” ХК-НЫ БАЙРАНД  
БОЛНО

## Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгүүд:

- ✓ Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- ✓ Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
- ✓ Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
- ✓ Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайлан
- ✓ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулга
- ✓ ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв
- ✓ Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр

### “БИ ДИ СЕК ҮЦК” ХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1

Холбоо барих утас: 99043146,  
95906390, 95956390



## АГУУЛГА

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах шийдвэр, хавсралт .....	3
хэлэлцэх асуудал 1. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт .....	11
хэлэлцэх асуудал 2. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан.....	18
хэлэлцэх асуудал 3. 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө.....	29
хэлэлцэх асуудал 4. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт .....	32
хэлэлцэх асуудал 5. Туз-ын ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчид....	34
хэлэлцэх асуудал 6. Туз-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв .....	44
хэлэлцэх асуудал 7. Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр .....	45
хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах шийдвэрийн төслүүд.....	46

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ ШИЙДВЭР, ХАВСРАЛТ



### Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017. 03. 16.

№ 12/02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал хуралдуулах тухай

“Э-транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Э-транс ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2017 оны 04 дүгээр сарын 28-ны 15 цагт “БиДиСек ҮЦК” ХК-ний төв байранд зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.

- a) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b) Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан,
- c) Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- d) Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
- e) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f) ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв батлах
- g) Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 18 дахь өдөр буюу 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөр тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг нийтэд мэдээлэх өдрийг хурал хуралдуулах тухай шийдвэр гарснаас хойш 4 дэх өдөр буюу 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээллэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримттай 2017 оны 03 сарын 24-ны өдрөөс хойш ажлын өдрүүдэд 08<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд “БиДиСек ҮЦК” ХК-ийн байранд ирж танилцах эрхтэй болохыг дурдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдрөөс ажлын 3 өдрийн өмнө байхаар тогтсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Энхболд, тооллогын комиссын даргаар М.Саранжаргал, гишүүнээр Ж.Ариунболд нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Ч.ЭНХБОЛД



## “Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Дорноговь аймаг, Замын-Үүд сум 1-р багт байрлах “Э-Транс Ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04-р сарын 28-ны өдөр 15:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд болно.

Хурал зохион байгуулах газрын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 27/1 “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2017 оны 04-р сарын 07-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- a) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b) Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
- c) Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- d) Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах
- e) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- f) ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв батлах
- g) Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын дарга Ганбат, гишүүн Ариунтуяа, Гэрэлт-Од нараас ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд холбогдох мэдээллийг авна уу.

Холбоо барих: 99043146, 95906390, 95956390

И-мэйл хаяг: [etranslogistics@hotmail.com](mailto:etranslogistics@hotmail.com), [etranslogistics999@gmail.com](mailto:etranslogistics999@gmail.com)

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны  
03 дугаар сарын 16-ний өдрийн 17/02  
дугаар тогтоолын “Хавсралт-1”

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	14:50-15:00
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	15:00-15:05
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	15:05-15:15
4	<b>Хурлаар хэлэлцэх асуудлууд</b>	
	Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт	15:15-15:30
	Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан	15:30-15:40
	Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	15:40-15:50
	Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах	15:50-16:05
	ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	16:05-16:20
	ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв батлах	16:20-16.25
	Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр танилцуулах	16:25-16:30
5	Асуулт хариулт	16:30-16:50
6	Санал хураалт	16:50-17:10
7	Хурлын завсарлага	17:10-17:15
8	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	17:15-17:30
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	17:30-17:35
10	Хурлыг хаах (хурлын дарга)	17:35-17:40

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны  
03 дугаар сарын 16-ний өдрийн 17/02  
дугаар тогтоолын “Хавсралт-2”

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

- a) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- b) Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
- c) Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
- d) Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайлан
- e) ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийн танилцуулга
- f) ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв
- g) Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэр

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны  
03-р сарын 16-ний өдрийн 17/02 дугаар  
тогтоолын “Хавсралт-3”

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

Регистерийн дугаар :

Санал өгөх хувьцааны тоо .....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

“Э-транс ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, “БиДиСек ҮЦК” ХК-ний төв байрны хурлын зааланд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт			
2.	Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан			
3.	Компанийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах			
4.	Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт бүхий тайланг батлах			
5.	ТУЗ-ийн 2017 оны цалин урамшууллын төсөв батлах			
6.	Ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах			

Брокер ..... Гарын үсэг  
/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч ..... Гарын үсэг

2017 оны ..... сар.....өдөр



ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана. Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100\*9гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу.

#### САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.

Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх талаарх мэдээллийг 99043146, 95906390 утсаар лавлаж болно.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

.....  
 .....  
 .....

2017 оны ..... сар..... өдөр

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1. КОМПАНИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТҮҮНД ХИЙГДСЭН ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



### “НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

2017 оны 2 сарын 10 өдөр

Улаанбаатар хот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК –ийн хувьцаа эзэмшигчдэд

Бид танай байгууллагын 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

#### *Зөрчилгүй дүгнэлт*

Танай байгууллага 2016 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв.

Уг стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн “Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага” хэсэгт харуулсан болно. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагын дагуу танай байгууллагаас хараат бусаар ажиллах үүргээ бүрэн биелүүлсэн билээ.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

#### *Аудитын гол асуудлууд*

Бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй зүйлсийг аудитын гол асуудлууд гэж үзнэ. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

#### *Бусад мэдээлэл*

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хамраагүй тул түүнд баталгаажуулалт гаргахгүй.

#### *Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг*

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь байгууллагын удирдлагын хүлээх үүрэг юм. Энэхүү үүрэгт залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан бэлтгэх, толилуулах үүрэг бүхий дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх ажлууд багтана. Удирдлага санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг цаашид тасралтгүй явуулах үүрэг хариуцлага хүлээсэн байна.

**Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх нь бидний үүрэг хариуцлага юм.

Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв. Аудит хийхдээ аудитын горим (Шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, тасалбар болголт, тулгах гэх мэт)-уудыг ашиглав.

Байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг баримталсан бөгөөд цаашид ч уг зарчмыг баримтлах юм байна.

**Тайлангийн зориулалт**

Энэхүү тайланг танай байгууллагын хувь нийлүүлэгчдэд зориулан бэлтгэв. Бид энэ тайлангийн агуулгын хүрээнд гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Аудиталсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.



*Signature*

Т.СУГАРСҮРЭН

### САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Э-Транс ложистикс

2016 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	90,754,968.17	4,597,711.28
1.1.2	Дансны авлага	23,716,200.00	1,265,000.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	3,692,299.12	493.00
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	70,057,209.73	92,143,605.19
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10	Хойшлогдсон татварын хөрөнгө		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>188,220,677.01</b>	<b>98,006,809.46</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,171,885,092.31	4,980,927,534.43
1.2.2	Биет бус хөрөнгө	845,357,461.75	773,850,038.75
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,062,012.70	
1.2.7	Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>6,018,304,566.76</b>	<b>5,754,777,573.18</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,206,525,243.77</b>	<b>5,852,784,382.64</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	117,205,764.00	104,167,614.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	1,352,755.00	24,771,706.27
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	199,361,276.77	0.00
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Суутган татварын өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
2.1.1.12	Хойшлогдсон татварын өглөг		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>317,919,795.76</b>	<b>128,939,320.27</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		149,459,000.00
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>149,459,000.00</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>317,919,795.76</b>	<b>278,398,320.27</b>
<b>2.3</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн	4,620,000,000.13	4,620,000,000.13
2.3.3	- Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00	154,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	774,858,080.00	774,858,080.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	339,747,367.87	25,527,982.23
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>5,888,605,448.00</b>	<b>5,574,386,062.36</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>6,206,525,243.77</b>	<b>5,852,784,382.63</b>

Ерөнхий захирал \_\_\_\_\_ ( Ч.Амарсанаа )

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....



## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Э-Транс ложистикс

2016 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 01-р сарын 01	2016 оны 01-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		553,480,607.36
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
3	Нийт ашиг (алдагдал)		553,480,607.36
4	Түрээсийн орлого		32,318,272.73
5	Хүүний орлого		1,222,858.25
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		61,517,394.55
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		911,424,399.37
11	Санхүүгийн зардал		32,130,933.24
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		592,133.48
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(18,611,020.86)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		(313,035,087.10)
19	Орлогын татварын зардал		1,184,298.54
20	Татварын дараах ашиг (алдагдал)		(314,219,385.64)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		(314,219,385.64)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		(314,219,385.64)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Ерөнхий захирал  ( Ч.Амарсанаа )Ерөнхий нягтлан бодогч  ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Э-Транс логистикс

2016 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 01-р сарын 01	2016 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>731,570,076.42</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		725,137,492.92
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		3,924,948.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтын орлого		
	Бусад мөнгөн орлого		2,507,635.50
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>		<b>747,413,740.65</b>
	Ажиллагчдад төлсөн		207,747,478.30
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө		47,470,187.00
	Бараа материал худалдан авахад төлсөн		171,888,287.40
	Ашиглалтын зардалд төлсөн		67,813,259.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		74,509,578.20
	Хүүний төлбөрт төлсөн		32,130,933.24
	Татварын байгууллагад төлсөн		74,046,120.54
	Даатгалын төлбөрт төлсөн		742,668.00
	Бусад мөнгөн зарлага		71,065,228.97
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(15,843,664.23)</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>10,584,658.25</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		9,361,800.00
	Хүлээн авсан хүүний орлого		1,222,858.25
	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>10,000,000.80</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		10,000,000.80
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>584,657.45</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>215,000,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		215,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>285,898,250.10</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		285,898,250.10
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(70,898,250.10)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(86,157,256.89)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>90,754,968.17</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>4,597,711.28</b>

Ерөнхий захирал  ( Ч.Амарсанаа )Ерөнхий нягтлан бодогч  ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....

ТТН4138 А.330955

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Э-Транс логистикс

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээ	Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДУН
<b>2015 оны 1-р сарын 1-ний үзлэгдэл</b>	4,620,000,000.13		154,000,000.00			774,858,080.00		<b>5,548,858,080.13</b>
Бүртгэлийн боллогын өөрчлөлт								
<b>Залруулсан үзлэгдэл</b>								
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							339,747,367.87	<b>339,747,367.87</b>
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдэл								
<b>2016 оны 01-р сарын 01-ний үзлэгдэл</b>	4,620,000,000.13		154,000,000.00			774,858,080.00	339,747,367.87	<b>5,888,605,448.00</b>
Бүртгэлийн боллогын өөрчлөлт								
<b>Залруулсан үзлэгдэл</b>								
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							(314,219,385.64)	<b>(314,219,385.64)</b>
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдэл								
<b>2016 оны 12-р сарын 31-ний үзлэгдэл</b>	4,620,000,000.13		154,000,000.00			774,858,080.00	25,527,982.23	<b>5,574,386,062.36</b>

Ерөнхий захирал \_\_\_\_\_ ( Ч.Амарсанаа )

Ерөнхий нягтлан болоч \_\_\_\_\_ ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....



## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2. КОМПАНИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

### **Компанийн эрхэлж буй үйл ажиллагааны салбарт эзлэх байр суурь**

Тус компанийн ажил үйлчилгээний гол хэлбэр нь ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэр дэх шилжүүлэн ачих бусад терминалуудаас дараах хүчин зүйлсээр давуу талтай байдаг.

1. Газар нутгийн байрлал: Компани нь БНХАУ-тай хиллэдэг улсын хилээс 5 км, худалдаа, аялал жуулчлалын чөлөөт бүс Эрээн хотоос 10 км, хилийн шалган нэвтрүүлэх 3-р цэгээс 100 метрийн зайд байрладаг.

2. Нэг дороос үйлчилгээ авах боломжтой: Тус компанийн гаалийн хяналтын бүсээр зарлагдан үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш гаалийн нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлэн үйлчлүүлэгч нарын цаг, хөдөлмөрийг хэмнэж ирсэн. Мөн ачаа барааг шилжүүлэн ачих ачигч нарыг үйлчлүүлэгч нарт зуучилан түргэн шуурхай найдвартай шилжүүлэн ачих үйлчилгээг үзүүлдэг.

3. Техник тоног төхөөрөмжийн цогц үйлчилгээ: Үйлчлүүлэгч нарын хүсэл шаардлагад нийцүүлэн ачаа барааг шилжүүлэн ачих ажиллагаанд техник тоног төхөөрөмжийг ашигласнаар шилжүүлэн ачих үйл ажиллагаа түргэн шуурхай, элдэв гологдолгүй, бүрэн бүтэн захиалагч нарт хүргэгдэх нөхцөл бүрддэг.

4. Харуул хамгаалалтын найдвартай байдал: Тус компани 24 цагийн харуул хамгаалалтыг харуул хамгаалалтын алба хаагч нараар гүйцэтгүүлдэг бөгөөд харуул хамгаалалтын пост, төв оффисоос хяналтын IP камерын системээр гаалийн хяналтын бүс, ачилтын талбай, орж гарах үүд зэрэг бүх газрыг хянадаг.

5. Гаалийн баталгаат агуулах, хяналтын бүсийн цогц үйлчилгээ: Үйлчлүүлэгч нар нь өөрийн ачаа бараагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу гаалийн баталгаат агуулах, гаалийн хяналтын бүсэд төлбөртэйгөөр хадгалуулах боломжтой.

Доорх хүснэгтэд тус суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа бусад терминалын байдлыг харуулав.

### Хүснэгт 1. Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байгаа бусад терминалууд

Терминал	Хилийн хяналтын цэгээс терминал хүртэлх зай	Үйл ажиллагааны чиглэл	Онцлог
УБ Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 1	6 км	Нарийн болон өргөн царигын вагон хооронд хүнд даацын ачаа шилжүүлэн ачих болох хялбар муудах ачаа, чингэлгийг шилжүүлэн ачдаг.	- Нэг цэгийн үйлчилгээ - Хүнд даацын ачаа шилжүүлдэг
УБ Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 2	4 км	Нарийн царигаас өргөн царигын вагонд болон автомашинаас вагонд чингэлэг шилжүүлэн ачдаг.	2016 оны 07 дугаар сарын 1-нээс чингэлэг буулгахыг больсон.
УБ Төмөр замын харьяа шилжүүлэн ачих өртөө 3	11 км	Автомашинаас вагонд цемент шилжүүлэн ачдаг.	Барилгын материал болон өргөн хэрэглээний бараа шилжүүлэн ачдаг.

Улаанбаатар төмөр замын шилжүүлэн ачих цогцолборууд нь тус компанийн шилжүүлэн ачих цогцолбороос байрлалын хувьд хол, нийт ачааны дийлэнх ачааг шилжүүлдэг 1 болон 2-р шилжүүлэн ачих цогцолборуудад хүрч очих замын асуудал хүндрэлтэй /Замын-Үүд сумын дундуур явах шаардлагатай болдог/ байдаг нь дээрх цогцолборуудаас давуу талтай болгож байдаг.


Гэхдээ вагон хангалтын хувьд Улаанбаатар төмөр замын Замын-Үүд өртөөнөөс шууд хамааралтай байдаг тул ачаа бараа байсан ч компанийн салбар замд вагон олгохгүй байх тохиолдол үүсдэг. Үүнийг Замын-Үүд өртөө болон тус компанийн хооронд байгуулсан хамтын ажиллагаа болон салбар замын гэрээгээр ямар нэгэн асуудалгүй зохицуулан ажиллаж байна.

Компанийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гарсан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл

**Хүснэгт 2. Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:**

Сар	Цемент	Барилгын төрөл бүрийн материал	Кран	Модон материал	Бусад	Нийт
1	16	33		10	54	<b>113</b>
2	32	6	3	2	39	<b>82</b>
3	130	48	2	10	5	<b>195</b>
4	452	63	7	10	17	<b>549</b>
5	602	66	10	9	12	<b>699</b>
6	402	82	1	14	19	<b>518</b>
7	299	45	5	7	20	<b>376</b>
8	233	61	1	12	5	<b>312</b>
9	47	45	1	5	8	<b>106</b>
10	3	51	-	3	2	<b>59</b>
11	-	35	-	2	4	<b>41</b>
12	-	14	-	3	2	<b>19</b>
<b>Нийт</b>	<b>2216</b>	<b>549</b>	<b>30</b>	<b>87</b>	<b>187</b>	<b>3069</b>

**График 1. 2015 оны мөн үеийг 2016 оны мөн үетэй харьцуулсан байдал**



Компанийн үндсэн үйл ажиллагааны өсөлт бууралтыг графикаас харвал 2016 онд өмнөх жилүүдээс эхлэн явагдсан улс орны эдийн засгийн хямрал, барилгын салбарын зогсонги байдал, худалдан авах чадварын бууралт, бараа

эргэлтийн багасалт зэрэг эдийн засгийн нөхцөл байдлыг даган буурсан байдалтай байна.

Үүнээс гадна Улаанбаатар төмөр замаас 2016 оны 01 сарын 01-нээс болон 2016 оны 07 дугаар сарын 01-нээс төмөр замын орон нутгийн харилцааны ачаа тээвэрлэлтийн тарифыг 20-30% нэмэгдүүлсэн нь иргэд, аж ахуйн нэгжээс төмөр замаар ачаа бараа тээвэрлүүлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэсэн. Энэхүү нэмэгдсэн тарифанд тус компанийн салбар замаар голчлон тээвэрлэгддэг цемент, барилгын материал, мод, модон материал, төмөр зэрэг ачаануудын тариф 5-20%, хоёр удаагийн нэмэлтээр 41% хүртэл нэмэгдсэн байдалтай байна. Мөн компанийн эзэмшлийн салбар замаар вагон тавьж өгсөн, татаж авсан тариф 22,800 төгрөгнөөс 30,000, салбар замд сэлгээ хийхэд мөрдөгдөх тариф 30,000 төгрөгнөөс 50,000 төгрөг болж нэмэгдсэн зэрэг эдийн засаг хүндэрсэн үед компанийн санхүүгийн байдалд нөлөөлөх шийдвэрүүд гарсан.

### **Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл;**

2016 оны эхний хагас жилд Улаанбаатар төмөр замаас харьяа шилжүүлэн ачих терминалууддаа үйлчлүүлэгч олж авах үүднээс өөрийн ачилтын тарифаа тодорхой хувиар 2 удаа багасгасан. Компанийн зүгээс үйлчлүүлэгчдээ алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор мөн тодорхой хувиар ачилтын зардлыг буулгасан, найдвартай хамтран ажиллагч байгууллага, иргэдэд зориулсан бонустай үйлчилгээ хэрэгжүүлсэн, сэлгээ таталт тавилтыг аль болох түргэсгэсэн зэрэг үйлчлүүлэгчдээ дэмжсэн үйл ажиллагаа явуулсаны үр дүнд одоо тодорхой тооны найдвартай үйлчлүүлэгчтэй болсон гэж үзэж болно. Улс орны эдийн засгийн байдал, валютын өсөлт, худалдан авах чадвар буурсан зэрэг шалтгаануудын улмаас үйлчлүүлэгчидийн ачаа барааны эргэлт саарах, зогсох зэрэг таагүй нөхцөл байдал гарсан.


Барилгын салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниуд, хувь хүмүүсийн БНХАУ-аас худалдан авсан барилгын материалын дийлэнх хэсгийг цемент эзэлдэг бөгөөд 2015 онд тус компанийн шилжүүлэн ачилтын 80,4%-ийг цемент дангаар эзэлж байсан бөгөөд 2016 онд ачигдсан цемент өмнөх оны мөн үеийнхээс -62,6% буурсан нь нийт ачилтыг ихээхэн хувиар багасгасан.

Ингэж цемент болон барилгын материалын импорт багассан бас нэг шалтгаан бол дотоодын барилгын материал үйлдвэрлэгчдийг дэмжсэн бодлоготой холбоотойгоор импортын цементны гаалийн татвар, төмөр замаар тээвэрлэх ачилтын тариф нэмэгдсэнээс үүдэлтэй юм.

### Хүснэгт 3. 2012-2016 онд ачигдсан вагоны тоо / сараар /

Сар	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
1.	194	228	170	100	113
2.	116	95	70	76	82
3.	265	262	334	439	195
4.	303	403	301	955	549
5.	351	360	291	946	699
6.	442	463	301	921	518
7.	534	511	450	989	376
8.	649	329	652	1062	312
9.	600	358	451	946	106
10.	379	436	231	647	59
11.	305	319	132	154	41
12.	307	117	156	134	19
<b>Дүн</b>	<b>4,445</b>	<b>3,881</b>	<b>3,539</b>	<b>7,369</b>	<b>3,069</b>

### График 2. 2012-2016 оны ачилт, буултын харьцуулсан үзүүлэлт / жилээр /



Гаалийн үйлчилгээг түргэн шуурхай нэг дороос үзүүлэх ажлын хүрээнд Замын-Үүд сум дахь гаалийн байгууллагатай хамтран экспортоор гарч байгаа бүх төрлийн ачааг тус компанийн баталгаажсан автопүүн дээр пүүлэн жин, тонныг баталгаажуулан улсын хилээр гаргах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн нийт 4 сая гаран төгрөгний зардлаар автопүүний байрыг засварлан 2017 оны 1 сараас эхлэн ажилд оруулсан. Ингэснээр төмөр замаар тээвэрлэгдэж байгаа экспортын ачаа буурч байгаа үед буултнаас олох орлогын тодорхой хувийг дээрх төрлийн үйлчилгээнээс нөхөх боломжтой болж байгаа юм. Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн хатуу хучилттай зам ашиглалтанд орсноор экспортын үйл ажиллагаа явуулдаг компаниуд нь автозамаар тээвэрлэлт явуулахыг илүүд үздэг болсон

бөгөөд автозамаар тээвэрлэхэд зардал бага, цаг хугацаа алдахгүй байдагтай холбоотой юм.

### Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаанд гарсан томоохон үйл явдлын талаарх мэдээлэл

Үндсэн үйл ажиллагааны орлого болох ачилт буултын орлого нь 2016 онд шинэчлэгдсэн Нэмэгдсэн өртөгийн албан татварын хуулийн дагуу татвар ногдох болсноор борлуулалтын орлогоос 42500.9 мянган төгрөг төгрөгийг нэмэгдсэн өртгийн албан татварт шилжүүлсэн. Мөн цементний тээврийн хөлсийг МЧ-3 2016.01.01-2016.03.31 хүртэл 10 000 төгрөгөөр, 2016 оны 04 дүгээр сарын 01-нээс 06 сарын 30-ны өдрийн хооронд тарифаа 25 000 төгрөгөөр бууруулсан ба хэрэглэгчээ алдахгүйн тулд компани дагаж 35 000 төгрөгөөр бууруулсан.

#### Хүснэгт 4. Орлогыг нэр төрлөөр нь харуулсан нь /мян төгрөг /

№	Орлогын төрөл	2015 он			2016 он			Зөрүү	Өсөлт бууралт
		Борлуулалт	НӨАТ	Цэвэр борлуулалт	Борлуулалт	НӨАТ	Цэвэр борлуулалт		
1	Ачилт	919,602.80	0%	919,602.80	453,657.90	41,241.27	412,416.27	(507,186.53)	-55,1%
2	Буулт	20,731.00	0%	20,731.00	13,853.00	1,259.36	12,539.64	(8,137.36)	-39,5%
3	Хадгалалт агуулах	234,827.20	21,347.93	213,479.27	90,978.92	8,270.81	82,708.11	(130,771.16)	-61,2%
4	Гарах хуудас	30,610.00	2,782.73	27,827.27	47,499.00	4,318.09	43,180.91	15,353.64	+35,5%
5	Түрээс	50,520.00	4,592.73	45,927.27	35,550.10	3,231.83	32,318.27	(13,609.00)	-29,6%
6	Цайны газар	77,900.70	7,081.88	70,818.82	67,669.10	6,151.74	61,517.36	(9,301.45)	-13,1%
7	Бусад	11,319.70	1,029.06	10,290.64	2,839.80	258.16	2,581.64	(7,709.00)	-75%
8	Хүүний орлого	2,419.80		2419.8	1222.8		1222.8		-49,4%
	<b>Нийт</b>			<b>1,311,096.87</b>			<b>648,539.00</b>	<b>662,887,87</b>	<b>-50,5%</b>

2016 онд тус компани 314,219.4 мян төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### Хүснэгт 5. Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо хураамж

Хяналтын бүс				Баталгаат агуулах			
2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он
6122	5967	27827,3	43180,1	21	3	213479,2	82708,1
Өсөлт, бууралт				Өсөлт, бууралт			
-2,5%		35,5%		-85,7%		-61.2%	

2016 оны 1-р сараас техникийн паспортын эх хувьгүй автомашинуудыг гаалийн баталгаат агуулахаар дамжуулан бүрдүүлэлт хийж байхаар журамласантай холбоотойгоор нийт 1.762.620.23 ам.долларын статистик дүн бүхий 495 автомашин баталгаат агуулахад түр хадгалуулан гарсан.

Гаалийн хяналтын бүсэд 2016 оны байдлаар 5472 тээврийн хэрэгсэл нэвтэрч гаалийн бүрдүүлэлт хийгдэн гарахад үйлчилгээний хураамжийг хурааж авчээ. Үүнээс гадна баталгаат агуулахад түр хадгалагдахаар орж ирсэн дээрх 495 автомашинуудыг хяналтын бүсэд нэвтрүүлэн үйлчилгээ үзүүлсэний хураамжийг авснаар хяналтын бүсэд нэвтэрсний хураамж нийт 43180,09 төгрөгийг орлогод авсан нь өмнөх оныхоос 15352,8 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Баталгаат агуулахын орлого -61,2% болтлоо буурсан шалтгаан нь 2013 оноос хойш хадгалагдаж байсан хүнд машин механизмийн хадгалалтын хугацаа дуусч гарсан ба манай улсын уул уурхайн салбар зогсонги байдалтай байгаагаас 2016 онд дээрх компаниуд хүнд оврын машин механизм оруулж ирж удаан хугацаагаар хадгалуулаагүйтэй холбоотой юм.

### Компанийн үйл ажиллагааны тогтвортой байдлын тайлан


Тус компани нь үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа буюу Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь байгууллага, аж ахуйн нэгжийн дунд томоохонд орох татвар төлөгч аж ахуйн нэгж юм. 2011-2016 онд төлсөн татварын хэмжээг хүснэгтээс харвал:

Татварын төрөл	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он
Үл хөдлөх хөрөнгийн орлогийн албан татвар	16,529,100	22,774,600	35,975,925	47,593,936	47,953,936	28,556,365
Авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар	231,600	433,400	282,118	464,740	574,900	482,275
Газрын төлбөр	320,000	320,000	480,000	400,000	400,000	400,000
Нэмэгдсэн өртгийн орлогын албан татвар	546,400	14,934,687	45,033,606	42,310,698	43,335,267	59,446,662
Хувь хүний орлогын албан татвар	3,326,846	9,678,791	13,892,548	16,472,167	20,397,566	22,411,896
Аж ахуйн	12,580,300	12,362,365	11,066,987	23,065,456	27,623,094	122,285

нэгжийн орлогын албан татвар						
Нийт дүн	33,534,246	60,503,843	106,731,184	130,306,997	140,284,763	111,419,483

Жич: Голлох татварын хэмжээг харуулав.

Үүнээс гадна нийгмийн даатгалын санд төлсөн даатгалын шимтгэлийг харвал:



2016 оны 02 дугаар сарын 05-д Дорноговь аймгий Замын-Үүд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээс “Хэрэглэгчдийн итгэмжит шилдэгийн шилдэг хамт олон”-оор шалгаруулан өргөмжлөл хадгалуулсан.

### Гүйцэтгэх удирдлага

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол, мэргэжил	Ажлын туршлага
1.	Чулуун Амарсанаа	Гүйцэтгэх захирал	Дээд, уулын инженер	Тус компанийг үүсгэн байгуулсан.
2.	Эрдэнэбаатар Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Дээд, математикч, нягтлан бодогч	2011 оноос хойш ажиллаж байна.
3.	Хаваан Батхишиг	Менежер	Дээд, бизнесийн удирдлага	2012 оноос хойш ажиллаж байна.
4.	Гомбо Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Дээд, багш	2011 оноос хойш ажиллаж байна.
5.	Нямсүрэн Баярмаа	Касс-нярав	Дээд, нягтлан бодогч	2012 оноос хойш ажиллаж байна.

### Төлөөлөн удирдах зөвлөл

д/д	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий захирал
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс Ложистикс ХК, Гүйцэтгэх захирал
3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	Дээд	Э-Транс ХХК, Ерөнхий менежер
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	Дээд	Мэдээлэл аудит ХХК, мэргэжилтэн
5.	Баярсайханы Пүрэвбаатар	ТУЗ-ын гишүүн	Дээд	Говь караван ХХК, Санхүүгийн шинжээч
6.	Батсүхийн Мянганбаяр	ТУЗ-ын түр гишүүн	Дээд	Говь караван ХХК, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	Дээд	Би Ди Сек ХК, Тэргүүн дэд захирал
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	Дээд	Оптималь проект ХХК, Захирал
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	Дээд	Нефть Ойл ХХК, Гүйцэтгэх захирал

**Компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл**

д/д	Овог нэр	Албан тушаал	Цалин урамшууллын хэмжээ	Эзэмшиж буй хувьцааны тоо
<b>Төлөөлөн удирдах зөвлөл</b>				
1.	Чулууны Энхболд	ТУЗ-ын дарга	0₮	Эзэмшдэггүй
2.	Чулууны Амарсанаа	ТУЗ-ын гишүүн	сарын 1.100.000	Эзэмшдэггүй
3.	Санжмятавын Отгонбаяр	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
4.	Сэджавын Санжаа	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
5.	Баярсайханы Пүрэвбаатар	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй

6.	Батсүхийн Мянганбаяр	ТУЗ-ын түр гишүүн	0₮	Эзэмшдэггүй
7.	Бүрэнмэндийн Лхагвадорж	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
8.	Ариунболдын Батболд	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
9.	Халтарын Батхишиг	ТУЗ-ын гишүүн	0₮	Эзэмшдэггүй
<b>Гүйцэтгэх удирдлага</b>				
1.	Эрдэнэбаатарын Ариунтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
2.	Хавааны Батхишиг	Менежер	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
3.	Гомбын Оюунгэрэл	Гаалийн хяналтын талбайн эрхлэгч	Сарын 1.000.000₮	Эзэмшдэггүй
4.	Нямсүрэнгийн Баярмаа	Касс-нярав	Сарын 700.000₮	Эзэмшдэггүй

**Компанийн тухай хуульд заасан их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээлэл;**

Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.

**Жилийн туршид авсан зээлийн жагсаалт, түүний эргэн төлөлт болон барьцаа, баталгаа гаргасан талаарх мэдээлэл**

Худалдаа хөгжлийн банкнаас 3 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн 200,000,000 сая төгрөгний зээл авч Хас банкинд дахь 99800 долларын зээлийг хаасан. Ам.долларын өсөлтөөс шалтгаалан ханшийн зөрүүний алдагдал их үүсч төлөлтийн явцад их алдагдалтай байдаг байсан бөгөөд ам.доллорын ханшийн өсөлт бууралтын ирээдүйн байдал цаашид ч мөн өсөх нөхцөл байдалтай байсан тул ТУЗ-ын гишүүдийн саналыг авч ТУЗ-ын шийдвэрийг үндэслэн зээл авсан. Зээлийн эргэн төлөлтийг гаргахдаа үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан хэрхэн зээлийн эргэн төлөлтийг хийж байхаар зээлийн хуваарийг гаргасан. Зээлийн барьцаа хөрөнгөнд нэг цэгийн үйлчилгээний барилгыг барьцаалсан.

**Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл;**

д/д	Нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1.	Э-Транс ХХК	Ачаа тээврийн компани	50%
2.	Би Ди Сек ҮЦК ХК	Брокер дилер, андеррайтерийн компани	31.73%
3.	Монголиан Транспортэйшн Холдинг ХХК	Хөрөнгө оруулалтын сан, Люксембургийн вант улс	11.08%

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болох Ч.Энхболд, гишүүн С.Отгонбаяр, Б.Пүрэвбаатар, Б.Мянганбаяр, Б.Лхагвадорж болон гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа нар нь компанийн хараат гишүүд бөгөөд А.Батболд, Х.Батхишиг, С.Санжаа нар нь компанийн хараат бус гишүүд болно.

**Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийн мэдээлэл;**

Компани нь Э-Транс ХХК, Монголиан Транспортэйшн Холдинг ХХК, БиДиСек ҮЦК ХК гэсэн 5%-иас дээш хувь эзэмшдэг хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 2016 онд нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсэд өөрчлөлт ороогүй болно.

### ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3. 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үндсэн үйл ажиллагаа	Хийгдэх ажил	Салбар ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	1. Үндсэн ажлын хүрээнд	1.1 Хяналт	Ачилт болон бусад шаардлагатай асуудлаар гүйцэтгэх удирдлагын баг 7 хоног бүрийн эхний өдөр хуралдаж тодорхой шийдвэрүүдийг гаргах,	2017 он	Гүйцэтгэх удирдлага
2			Компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа тушаал, шийдвэр, дүрэм, заавруудын биелэлтэнд хяналт тавьж ажиллах,	2017 он	Гүйцэтгэх удирдлага
3			Компанийн ажилчид ажил үүргээ гүйцэтгэхдээ хууль тогтоомж зөрчиж байгаа эсэхэд хариуцсан чиглэлийн дагуу хяналт тавьж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах,	2017 он	Гүйцэтгэх удирдлага
4			Ажилчдад хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтонд заагдсан ажил үйлчилгээг үр дүнтэй, чанартай хийж гүйцэтгэхэд заавар зөвөлгөө өгч ажиллах,	2017 он	Гүйцэтгэх удирдлага
5			Ажилчид болон гүйцэтгэх удирдлагын баг нь өөрийн үйл ажиллагаа, харицааны асуудалд онцгой анхаарч ажиллах ба Компанийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажиллах,	2017 он	Нийт ажилчид
6		1.2 Вагон ачилтыг нэмэгдүүлэх, үндсэн үйл ажиллагааг сайжруулах	2016 онд төлөвлөгдсөн боловч тодорхой шалтгааны улмаас тасарсан / 1.1 дэх хэсгийн 4 төрлийн ажлыг / ажлуудыг хийж гүйцээх, компанийн урт болон богино хугацааны бизнес төлөвлөгөөг гарган батлуулан, мөрдөж ажиллах,	2017 оны 1-р улирал	Х.Батхишиг
7			Төмөр замтай байгуулах гэрээ, хэлцлүүдийг байгуулах, хугацаа дуусмагц сунгах, гэрээний дүнг хэлэлцэх,	1-р сар	Х.Батхишиг
8			Ачилтын төлөвлөгөөний дагуу төлөвлөсөн ачааг ачих боломжийг судлан үйлчлүүлэгч татах ажлыг оновтой хэлбэрээр зохион байгуулах,	2017 он	Х.Батхишиг
9			Ачилтын төлөвлөгөө тасрахаас / жилд 5710 вагон ачаа / сэргийлэх, тухайн үед зайлшгүй авч хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган танилцуулан төлөвлөгөөний дагуу ажиллах,	2017 он	Х.Батхишиг В.Баасансүрэн Ачаа тээврийн алба
10			Вагон ашиглалтын хугацааг багасгах, пүүлэгч нарын ажлын идэвх санаачилгыг дээшлүүлэх, тэднийг байнгын удирдлагаар хангах,	2017 он	Х.Батхишиг В.Баасансүрэн Ачаа тээврийн алба
11			Гаалийн байгууллагатай хамтран экспортын ачааг компанийн автопүүгээр пүүлүүлэх ажлыг зохион байгуулах,	2017 он	Э.Ариунтуяа В.Баасансүрэн
12			Импортоор автомашинтай орж ирж байгаа чингэлгийн ачаа, барааг өөрийн талбайд буулгах ажлыг онцгой анхааран холбогдох хүмүүстэй	2017 он	Х.Батхишиг

			уулзаж гэрээ байгуулан хамтарч ажиллах,			
13		1.3 Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын үйл ажиллагааг зохион байгуулах	Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын өнгө үзэмж, эмх цэгцийг байнга шалгаж шаардлагатай ажлуудыг танилцуулан хийж ажиллах,	2017 он	Г.Оюунгэрэл	
14			Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахад хадгалагдаж байгаа тээврийн хэрэгсэл, ачаа барааны тайланг сар, улирал, жилээр гарган холбогдох газарт хүргүүлж байх бөгөөд 1 хувийг дотоод ажилтанд өгч нэгтгүүлж байх,	2017 он	Г.Оюунгэрэл	
15			Гаалийн хяналтын бүс, баталгаат агуулахын харуул хамгаалалтыг хариуцаж байгаа гэрээт харуул хамгаалалтын албатай хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний үүргийг чанд мөрдүүлж ажиллах,	2017 оны 1-р сар	Г.Оюунгэрэл	
16		1.4 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг сайжруулах, ажилтны аюулгүй ажиллах нөхцлийг хангах, тэдний үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх,	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр сургалтыг улирад бүр зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаас сургагч багш урьж авчиран ажилчдад сургалт оруулж байх,	2017 он	Х.Батхишиг	
17			Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгыг тогтоосон хугацаанд өгч өгсөн зааварчилгыг ажилтны хувийн хэрэгт хавсаргаж байх,	2017 он	Х.Батхишиг	
18			Өдөр тутмын зааварчилгыг ажилтан бүрийг өглөө ажилд гарахаас өмнө өгч гарын үсэг зуруулж байх,	2017 он	Цех, тасгийн дарга нар	
19			Ажилтанд орж байгаа өөрийн ажилчид болон баригадуудын ажилчин бүрт хөдөлмөр хамгаалалын зааварчилга өгч гарын үсэг зуруулж хадгалж байх,	2017 он	Ачаа тээврийн алба, пүүлэгч нар	
20			Хөдөлмөр хамгаалалын хувцас хэрэгслийн бүрэн бүтэн байдал, эдэлгээний норм хугацаа дууссан эсэхийг ажлын жилийн эхэнд үзэж танилцуулан шаардлагатай хувцас хэрэгслийг нөхөж авах, хувцас хэрэгслийг картлан ажилтад тавьж олгох,	2017 оны 1-р сар	Э.Ариунтуяа Х.Баярмаа	
21			Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дүрэм журам зөрчигдөж байгаа эсэхэд байнгын үзлэг шалгалт зохион байгуулах,	Сард 2 удаа	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн зөвлөл	
22			Аюулыг мэдэгдэх хуудасны ашиглалтыг нэмэгдүүлэх, ажилтан бүрт энэ талаар үүрэг даалгаврыг ХАБЭАхуйн зааварчилгын хамт өгөх,	2017 он	Х.Батхишиг	
23	2. Дотоод ажил	2.1 Засвар үйлчилгээ	2016 онд эдийн засгийн байдал, компанийн санхүүгийн байдлаас шалтгаалан хийж гүйцэтгэж чадаагүй засвар үйлчилгээнүүдийг хийж гүйцэтгэх,	2017 он	Механик цех	
24				Ажилтын талбай дахь ажилчдын вагончикийг засаж янзлах,	2017 оны 3 сар	Механик цех
25				Гадна хашааны дотор талыг шохойдох,	2017	Механик цех

			сэрэмжлүүлэх бичгүүдийг будаж тодруулах,	оны 8 сар	
26			Нохойны байрны цэвэрлэгээг хийх, хашааг шинээр бэхэлж янзлах,	2017 оны 4 сар	Г.Ганболд
27			Машин тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн үзлэг, тооллогод хамруулах,	2017 он	Х.Батхишиг Механик цех
28			1-р грашид хийгдэх багаж хэрэгсэл хадгалах байр, бичил засварын газар байгуулах ажлыг хийж гүйцэтгэх,	2017 он	Механик цех
29			Шинээр бохирын цооног хийж гүйцэтгэх	2017 6 сар	Механик цех
30		2.2 Техник технологийн шинэчлэлт	Эдийн засаг, компанийн санхүүгийн байдлаас шалтгаалж 2016 онд хийгдээгүй ажлыг хийж гүйцэтгэх боломжтой эсэхийг судлах, мөн худалдан авах зайлшгүй шаардлагатай байгаа эсэхийг судлан ТУЗ-д танилцуулж шийдвэрлүүлэх,	2017 онд	Ч.Амарсанаа Э.Ариунтуяа
31			Чингэлэг өргөх хүнд ачаа / 40-100 тн / өргөх зориулалттай вандан кран авах бололцоог судлах,	2017 он	Ч.Амарсанаа Э.Ариунтуяа
32	3. Сургалт, нийгмийн хамгаалал	3.1 Сургалт соён гэгээрүүлэх ажил	Ажлын ачаалал багатай саруудад ажилчдыг компанийн зардлаар мэрэгшүүлэх сургалтанд хамруулах нөхцлийг судлан танилцуулах	2017 оны 1, 2-р улирал	Х.Батхишиг Э.Ариунтуяа
33			Өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа дүрэм журмаар сургалт зохион байгуулах	2017 онд	Х.Батхишиг
34			Бусад байгууллагуудаас сургагч багш нарыг урьж ажилчдад сургалт оруулах	2017 он	Х.Батхишиг
35			Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор уралдаан тэмцээн, тэмдэглэлт баярн үеэр зохион байгуулдаг арга хэмжээнүүдийг уламжлал ёсоор зохион байгуулах	2017 он	Зохион байгуулахаар томилогдсон комисс
36		3.2 Нийгмийн хамгаалал	Компанид олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилчдын хүүхдийн цэцэрлэг сургуулийн сургалтын төлбөрийг төлөх, судалгааг гаргаж танилцуулах,	2017 оны 3-р улирал	Э.Ариунтуяа
37			Ажилчдыг компанид тогтвор суурьшилтай, идэвхитэй ажиллахад нөлөөлөхүйц нийгмийн хамгаалалын тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэх,	2017 оны 3-р улирал	Ч.Амарсанаа Э.Ариунтуяа
38			Компанийн дотоод журамд заагдсан бусад нийгмийн хамгаалалын асуудлыг хэрэгжүүлэх,	2017 он	Ч.Амарсанаа Х.Батхишиг
39	Компанийн ногоон байгууламжийг сэргээн засварлах, элс шороог зйлуулах, байнгын усалгаатай байлгах, шинээр 1-2 төрлийн мод, бутыг агуулахын урд хэсгээр тарих,		2017 он	Г.Оюунгэрэл хариуцаж нийт ажилчид оролцоно.	
<b>Нийт 3 бүлэг, 39 ажил төлөвлөв.</b>					

## **ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4. КОМПАНИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, КОМПАНИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТ**

“Э-Транс ложистикс” ХК-ны 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн дүгнэснийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд танилцуулж байна.

“Э-Транс ложистикс” ХК нь 2016 онд 314,219.4 мян төгрөгийн алдагдалтай ажилласан..

Алдагдалтай ажилласан гол шалтгааныг үндсэн үйл ажиллагаа болох төмөр замаар ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа багассан, улс орны эдийн засгийн огцом уналт, иргэд, аж ахуйн нэгжийн худалдан авах чадвар муудсан зэрэг гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан байна гэж дүгнэж байна.

2015 онд тус компанийн шилжүүлэн ачилтын 80,4%-ийг цемент дангаар эзэлж байсан бөгөөд 2016 онд ачигдсан цемент өмнөх оны мөн үеийнхээс -62,6% буурсан нь нийт ачилтыг ихээхэн хувиар багасгаж үүнийг дагаад борлуулалтын орлого тодорхой хэмжээгээр буурсан..

Мөн 2016 онд шинэчлэгдсэн Нэмэгдсэн өртөгийн албан татварын хуулийн дагуу ачилт буулгалтын орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох болсон бөгөөд борлуулалтын орлогоос 42.500.9 мянган төгрөг төгрөгийг энэ татварт шилжүүлсэн нь гол үйл ажиллагаанаас олсон орлогын 9% болж байна.

Үүнээс гадна цементний тээврийн хөлс /тариф/-ийг Улаанбаатар төмөр замын шийдвэрээр 2016.01.01-2016.03.31-ний хооронд 10 000 төгрөгөөр, 2016 оны 04 дүгээр сарын 01-нээс 06 сарын 30-ны хооронд дахин 25 000 төгрөгөөр бууруулсан бөгөөд хэрэглэгчээ алдахгүйн тулд 35 000 төгрөгөөр бууруулсан нь нэгжээс олох орлогыг бууруулахад тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.

Компанийн гүйцэтгэх удирдлага эдийн засаг, санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдлыг эрсдэлгүй даван туулахын тулд харуул хамгаалалтын зардлаа багасгах, ажилчдыг түр хугацаанд өөр ажилд томилох, хамтран ажиллагч төрийн болон хувийн байгууллага аж ахуйн нэгжтэй уулзалт зохион байгууан хамтран ажиллах гэрээ байгуулах зэрэг бололцоотой бүх арга хэмжээнүүдийг авснаар компанид ашигтай зарим ажлуудыг шийдвэрлэж чаджээ.

Жишээлбэл: Худалдаа хөгжлийн банкнаас 3 жилийн хугацаатай сарын 1,8%-ийн 200,000,000 сая төгрөгний зээл авч Хас банкинд дахь 99.800 долларын зээлийг хааж дуусгасан. Тухайн үед ам.долларын өсөлтөөс шалтгаалан ханшийн зөрүүний алдагдал их үүсч төлөлтийн явцад их алдагдал хүлээх байсан ба цаашид ч ам.долларын ханш нь өсөх магадлалтайг соргоогоор харж асуудлыг ТУЗ-аар оруулан шийдвэрлэсэн байна.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь гаалийн байгууллагатай хамтран экспортоор гарч байгаа бүх төрлийн ачааг тус компанийн баталгаажсан автопүүн дээр пүүлэн жин, тонныг баталгаажуулан улсын хилээр гаргах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажилд оруулсан. Ингэснээр төмөр замаар тээвэрлэгдэж байгаа экспортын ачаа буурч байгаа үед буултнаас олох орлогын тодорхой хувийг дээрх төрлийн үйлчилгээнээс нөхөх боломжтой болсон байна.

“ Э-Транс Ложистикс “ ХК-ны 2016 оны жилийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг зөвлөлөө.

1. Улс орны санхүү, эдийн засгийн таагүй уур амьсгалыг даган үйл ажиллагаагаа бууруулах биш эрхэлж байгаа үйл ажиллагааны хүрээг өргөжүүлэхэд чиглэсэн ажлуудыг хийх, өөрөөр хэлбэл ачаа тээврийн бусад төрөл, чиглэлүүдийг эрхлэх боломжийг судлах,

2. Дээрх асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай төсөл, төлөвлөгөөг боловсруулан Төлөөлөн удирдах зөвлөлөөр оруулж санхүү, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлэх,

3. 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1-р бүлгийн 1.2.4-т заагдсан 2017 онд нийт ачих ачаа буюу 5710 вагон ачаа тээвэрлэхээр төлөвлөсөн ажлыг биелүүлэхэд анхаарч төлөвлөгөөний дагуу ажиллах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэхийг даалгалаа.

Тус компанийн гүйцэтгэх удирдлагыг 2016 онд ажилчид хамт олноо сайн удирдан зохион байгуулж, алдагдалтай ажилласан ч компанийн санхүүгийн байдлыг маш хүндрэлтэй нөхцөл байдалд оруулалгүй ажиллаж чадсан байна гэж дүгнэж байна.

## **“ Э-ТРАНС ЛОЖИСТИКС “ ХК-НЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5. ТУЗ-ЫН ЕРДИЙН БОЛОН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

### “Э-Транс Ложистикс” ХК-ийн ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч Чулуун овогтой Энхболдын тодорхойлолт

#### 1. Товч танилцуулга

Овог нэр: Чулуун овогтой Энхболд

Төрсөн он: 1967 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн ерөнхий захирал



#### 2. Боловсрол

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

#### 3. Ажлын туршлага

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин

1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга

1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга

1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Чулуун овогтой Амарсанаагийн тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Чулуун овогтой Амарсанаа

Төрсөн он: 1961 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1969	1979
2	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль		1979	1984
3	БНСЧС улсын Коопцинице мэргэжил дээшлүүлсэн		1989	1990

**3. Ажлын туршлага**

1984-1985 онд Бугантын алтны үйлдвэрт засварчин, туслах эксваторчин

1985-1991 онд Цагаан дэлийн уурхай, ерөнхий механик

1991-1995 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэр, Ерөнхий инженер дарга

1995-2002 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэрийн харьяа Хавчуургын алтны уурхай, ерөнхий инженер дарга

2002-2011 онд Э-Транс ХХК, гүйцэтгэх захирал

2011 оноос Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Санжмятав овогтой Отгонбаярын тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Санжмятав овогтой Отгонбаяр  
Төрсөн он: 1976 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК, ерөнхий менежер



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	Худалдаа үйлдвэрийн дээд сургууль	Бизнесийн удирдлага	1993	1997
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

**3. Ажлын туршлага**

2002-2003 онд Монгол Хатгамал ХХК  
2005-2006 онд Амиго Трейд ХХК

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Баярсайхан овогтой Пүрэвбаатарын тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Баярсайхан овогтой Пүрэвбаатар

Төрсөн он: 1986 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Санхүүгийн шинжээч, “Си Би Эм” ХХК



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1994	2004
2	Санхүү эдийн Засгийн Дээд сургууль	Бизнес удирдлагын бакалавр	2004	2010
3	University Tomas Bata in Zlin, Czech Republic	Business Administration	2007	2009

**3. Ажлын туршлага**

2010 – 2011      Корпорацийн санхүүч, “Фронтинер Секюритис” ХХК

2011 оноос      ТУЗ-ын нарийн бичгийн дарга, “Бэрх Уул” ХК

2011 оноос      Санхүү эрхэлсэн дэд захирал, “Би Эй Пи” ХХК

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Батсүх овогтой Мянганбаярын тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Батсүх овогтой Мянганбаяр

Төрсөн он: 1987 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “Говь Караван” ХХК, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	St.Benedicts Prep High School, USA		2004	2006
3	St.John`s University, USA		2006	2011

**3. Ажлын туршлага**

2011-2016 онд СиБиЭм ХХК-нд Аналист, ПР, Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

2016 оноос Говь Караван ХХК-нд Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Бүрэнмэнд овогтой Лхагвадоржийн тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Бүрэнмэнд овогтой Лхагвадорж

Төрсөн он: 1976 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	ШУТИС	Нефтийн инженер	1993	1997

**3. Ажлын туршлага**

1997 оноос БиДиСек ҮЦК ХК, тэргүүн дэд захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Хүрэлбаатар овогтой Болдын тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Хүрэлбаатар овогтой Болд

Төрсөн он: 1987 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “ БиДиСек ҮЦК ” ХК-нд мэргэжилтэн



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1995	2005
2	Зохиомж дээд сургууль		2005	2009

**3. Ажлын туршлага**

2009 оноос “ БиДиСек “ ХК-нд нярав

2013 оноос “ РАЭБ” ХХК-нд нягтлан бодогч

2013 оноос “ БиДиСек “ХК-нд мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Сэджав овогтой Санжаагийн тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Сэджав овогтой Санжаа

Төрсөн он: 1959 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Мэдээлэл-Аудит ХХК, мэргэжилтэн



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1967	1977
2	Санхүү Эдийн Засгийн Техникум		1977	1979

**3. Ажлын туршлага**

1979-1981 онд Түлээний трест, тооцооны ба ерөнхий нягтлан бодогч

1981-1990 онд Сэлэнгэ аймаг, Дулаанхан Түнхэл, Бугантын модны үйлдвэр, ерөнхий нягтлан бодогч

1990-2001 онд Эрдэнэтийн модны үйлдвэр, ерөнхий нягтлан бодогч

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Ариунболд овогтой Батболдын тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Ариунболд овогтой Батболд  
Төрсөн он: 1968 он  
Иргэний харьяалал: Монгол  
Эрхэлж байгаа ажил:



**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль		1985	1991
3	Удирдлыагын академи	Бизнесийн удирдлагын магистр	2004	2006

**3. Ажлын туршлага**

1996-1997 онд УБТЗ-ын УБ өртөө, Холбогч найруулагч  
1997 онд УБТЗ-ын олон улсын тээвэр зуучлалын төв  
1997-1998 онд УБТЗ-ын өртөө Ерөнхий инженер  
1998-2001 онд УБТЗ-ын ачиж буулгах тээвэр экспедицийн механикжсан анги, Орлогч дарга  
2001-2004 онд УБТЗ-ын техник технологийн хэлтэс, Дарга  
2004-2008 онд УБТЗ-ын техникийн бодлогын алба, Дарга  
2008-2011 онд “Монголын төмөр зам” ТӨХК, гүйцэтгэх захирал  
2011 онд УБТЗ-ын удирдах газар, даргын зөвлөх  
2011 онд “Оптимальный проект” ХХК захирал

**“Э-Транс Ложистикс” ХК-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Халтар овогтой Батхишигийн тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Халтар овогтой Батхишиг

Төрсөн он: 1974 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “Нефть Ойл” ХХК-ийн гүйцэтгэх захирал

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	ШУТИС	Инженер		

**3. Ажлын туршлага**

“Нефть Ойл” ХХК-ийн гүйцэтгэх захирал

## ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6. ТУЗ-ИЙН 2017 ОНЫ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ТӨСӨВ

2017 оны ТУЗ-ын зардлын төсөв

	<b>Зардлын нэр</b>	<b>Нэгжийн зардал</b>	<b>Зардлын дүн / төгрөг /</b>
1	ТУЗ-ын гишүүдийн цалин	-	-
2	ТУЗ-ын нарийн бичгийн цалин	240,000*4	960,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	1,000,000	1,000,000
4	ТУЗ-ын хурлын зардал	1,000,000	1,000,000
5	Томилолтын зардал	1,000,000	1,000,000
6	Бичиг хэргийн зардал	100,000	100,000
7	Бусад / ХЭХ-ын зар гаргах /	500,000	500,000
	<b>Дүн</b>		<b>4,560,000</b>

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 7. НОГДОЛ АШИГ ТАРААХГҮЙ ТУХАЙ ШИЙДВЭР**

**Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2017. 02 13№ 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай Монгол улсын хуулийн 46-р зүйлийн 46.5 дахь заалт, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 02-р сарын 13-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Э-Транс Ложистикс" ХК-ны 2016 оны үйл ажиллагаанаас ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал Ч. Амарсанаад үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ч.ЭНХБОЛД

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСЛҮҮД**

Төсөл

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017.04.28

№1

Улаанбаатар хот

**Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус  
аудитын дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг хэлэлцэж баталсугай.

Хурлын дарга: ...../

/

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017.04.28

№2

Улаанбаатар хот

**Компанийн үйл ажиллагааны  
тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлөөс үйл ажиллагааны талаар гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: .....

/

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017.04.28

№4

Улаанбаатар хот

**Компанийн 2017 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөөг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
2. Төлөвлөгөөнд дурьдагдсан ажлуудыг чанартай хийж гүйцэтгэх, биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэх захирал / Ч.Амарсанаа/-д даалгасугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017.04.28

№3

Улаанбаатар хот

**Компанийн 2016 оны үйл ажиллагааны  
тайлан, санхүүгийн тайлангийн талаар  
ТУЗ-ын дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаар гаргасан ТУЗ-ын дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй.
2. Үйл ажиллагааны төлөвлөгөө, гаргасан зөвлөмжийн гүйцэтгэлд анхаарч ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2017.04.28

№5

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат гишүүдээр
  - 1) .....
  - 2) .....
  - 3) .....
  - 4) .....
  - 5) .....
  - 6) .....
  
2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
  - 1) .....
  - 2) .....
  - 3) .....
  - 4) ..... нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017.04.28

№6

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг 4,560,000 төгрөгөөр тогтоосугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2017.04.28

№7

Улаанбаатар хот

**Компанийн ногдол ашиг тараахгүй тухай**

“Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас  
**ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулсан Ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг зөвшөөрсүгэй.

Хурлын дарга: ...../

/



